



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өндөршил сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2024/128/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a> Дундговь аймаг 2024 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Narantsatsralkh@audit.gov.mn">Narantsatsralkh@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК Захирал: Х.Ариунзул Утас: 99077062 Цахим хаяг: <a href="mailto:ikhayadaudit@gmail.com">ikhayadaudit@gmail.com</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Д.НОМИН-ЭРДЭНЭ ТАНАА

2024 - 02 - 26 № 90

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Өндөршил сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Өндөршил сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр, эрхлэгчийн А/24 тоот тушаалын дагуу 26,639.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 5,640.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил нийт 31,860.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ашиглалтын хугацааг сунгаж, бүртгэл тайланд тусгасан байна. Уг уйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

### Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын бичиг баримт болон хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг 92 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>54,713,783.60</b>	<b>112,157,411.74</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>4,134,990.11</b>	<b>55,678,198.25</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>4,134,990.11</b>	<b>55,678,198.25</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>4,134,990.11</b>	<b>55,678,198.25</b>
31211	Төрийн сангийн харилцах	1,104,145.00	54,293,303.14
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	3,030,845.11	1,384,895.11
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>50,578,793.49</b>	<b>56,479,213.49</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>13,121,349.61</b>	<b>14,194,149.61</b>
35110	Тусгай зориулалттай материал	13,121,349.61	14,194,149.61
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>37,457,443.88</b>	<b>42,285,063.88</b>
35420	Аж ахуйн материал	33,530,843.88	36,628,213.88
35450	Барилгын засварын материал	356,000.00	2,425,000.00
35460	Хүнсний материал	3,570,600.00	3,231,850.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,203,327,820.35</b>	<b>1,176,207,111.88</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,203,327,820.35</b>	<b>1,176,207,111.88</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,192,214,220.35</b>	<b>1,164,689,111.88</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,114,975,677.29	1,114,975,677.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,879,503.82)	(62,688,862.62)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	89,628,190.38	93,184,890.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,829,582.15)	(26,505,484.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,036,093.93	69,256,093.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,596,655.68)	(27,153,203.38)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,300,000.00	6,300,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,419,999.60)	(2,679,999.36)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>11,113,600.00</b>	<b>11,518,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	11,113,600.00	11,518,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН Ш=I+II</b>	<b>1,258,041,603.95</b>	<b>1,288,364,523.62</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,083,054.31</b>	<b>3,103,115.31</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,083,054.31</b>	<b>3,103,115.31</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>1,083,054.31</b>	<b>3,103,115.31</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	273,224.31	0.31
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	382,150.00	3,103,115.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>427,680.00</b>	<b>-</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	427,680.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,256,958,549.64</b>	<b>1,285,261,408.31</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,256,958,549.64</b>	<b>1,285,261,408.31</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	92,323,002.77	92,323,002.77
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	-	92,323,002.77
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	92,323,002.77	-
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,115,595,879.74</b>	<b>1,143,898,738.41</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(141,324,322.72)	1,115,595,879.74
51220	Тайлант үеийн үр дүн	1,256,920,202.46	28,302,858.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	49,039,667.13	49,039,667.13
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,258,041,603.95</b>	<b>1,288,364,523.62</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,623,364,996.73</b>	<b>472,088,857.51</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,308,148,696.73</b>	<b>41,219,257.51</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,308,148,696.73</b>	<b>41,219,257.51</b>

Дундговь аймгийн Өндөршил сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>14,695,416.95</b>	<b>200,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,134,345.11	200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,561,071.84	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,245,566,061.44	37,268,257.51
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	47,887,218.34	3,751,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>315,216,300.00</b>	<b>430,869,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>263,972,900.00</b>	<b>386,253,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	263,972,900.00	386,253,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>51,243,400.00</b>	<b>44,616,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,243,400.00	44,616,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>365,334,814.23</b>	<b>443,785,998.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>365,334,814.23</b>	<b>443,785,998.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>365,183,126.17</b>	<b>443,773,834.43</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>214,418,658.31</b>	<b>261,788,453.21</b>
210101	Үндсэн цалин	152,663,986.31	192,232,658.96
210102	Нэмэгдэл	38,953,215.00	52,516,580.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,490,000.00	9,760,000.00
210104	Урамшуулал	16,311,457.00	7,279,214.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,213,398.00</b>	<b>32,824,984.65</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,837,663.97	22,331,061.91
210202	Тэтгэмжийн даатгал	2,058,883.00	2,612,856.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,700,117.11	2,116,090.60
210204	Ажилгүйдлийн даатгал	418,608.92	521,576.51
210205	Эрүүл мэндийн даатгал	4,198,125.00	5,243,399.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,043,429.94</b>	<b>44,572,850.59</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,653,029.94	5,551,235.59
210302	Түлш, халаалт	29,040,400.00	38,099,115.00
210303	Цэвэр, бохир ус	1,350,000.00	922,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,028,904.85</b>	<b>5,549,500.00</b>
210401	Бичиг хэрэг	82,500.00	133,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,410,300.00	2,015,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	550,100.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	969,900.00	1,540,700.00
210408	Бараа материал акталсны зардал	2,016,104.85	1,859,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>21,004,475.00</b>	<b>26,363,330.00</b>
210502	Хоол, хүнс	21,004,475.00	26,363,330.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,430,700.00</b>	<b>1,065,100.00</b>
210604	Урсгал засвар	3,430,700.00	1,065,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>588,000.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	588,000.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>592,000.00</b>	<b>666,300.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	666,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>56,863,560.07</b>	<b>70,943,315.98</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,837,180.00	4,552,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,298,700.00	1,229,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,727,680.07	65,161,865.98
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>151,688.06</b>	<b>12,164.41</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>151,688.06</b>	<b>12,164.41</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	151,688.06	12,164.41

<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,258,030,182.50</b>	<b>28,302,858.67</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,109,980.04</b>	<b>0.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	1,109,980.04	0.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>1,256,920,202.46</b>	<b>28,302,858.67</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>318,350,645.11</b>	<b>431,069,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,134,345.11</b>	<b>200,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,134,345.11</b>	<b>200,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>3,134,345.11</b>	<b>200,000.00</b>
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	200,000.00
120004 7	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	3,030,845.11	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>315,216,300.00</b>	<b>430,869,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>263,972,900.00</b>	<b>386,253,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	263,972,900.00	386,253,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>51,243,400.00</b>	<b>44,616,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,243,400.00	44,616,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>314,215,655.00</b>	<b>378,753,491.86</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>314,215,655.00</b>	<b>378,753,491.86</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>314,063,966.94</b>	<b>378,741,327.45</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>214,225,232.00</b>	<b>261,977,872.17</b>
210101	Үндсэн цалин	152,470,566.00	192,438,250.92
210102	Нэмэгдэл	38,953,215.00	52,500,407.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,490,000.00	9,760,000.00
210104	Урамшуулал	16,311,451.00	7,279,214.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,133,600.00</b>	<b>32,908,789.69</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,757,865.97	22,386,825.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,058,883.00	2,619,446.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,700,117.11	2,121,322.59
210204	Ажилгүйдлийн даатгал	418,608.92	524,716.89
210205	Эрүүл мэндийн даатгал	4,198,125.00	5,256,478.47
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,146,679.94</b>	<b>41,469,735.59</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,653,029.94	5,551,235.59
210302	Түлш, халаалт	29,040,400.00	34,996,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,453,250.00	922,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>24,304,255.00</b>	<b>26,024,580.00</b>
210502	Хоол, хүнс	24,304,255.00	26,024,580.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,586,700.00</b>	<b>3,134,100.00</b>
210604	Урсгал засвар	2,586,700.00	3,134,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>592,000.00</b>	<b>666,300.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	666,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,075,500.00</b>	<b>12,559,950.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,825,500.00	10,561,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	1,998,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>151,688.06</b>	<b>12,164.41</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>151,688.06</b>	<b>12,164.41</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	151,688.06	12,164.41
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>4,134,990.11</b>	<b>52,316,108.14</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>772,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>772,900.00</b>

Дундговь аймгийн Өндөршил сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2200	Дотоод эх үүсвэрээр	-	772,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	772,900.00
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	<b>(772,900.00)</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>4,134,990.11</b>	<b>51,543,208.14</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,134,990.11
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,134,990.11	55,678,198.25

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31 үлдэгдэл	92,323,003	49,039,667	(141,324,323)	38,347
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>92,323,003</b>	<b>49,039,667</b>	<b>(141,324,323)</b>	<b>38,347</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	1,256,920,202	1,256,920,202
2022 оны 12-р сарын 31 үлдэгдэл	<b>92,323,003</b>	<b>49,039,667</b>	<b>1,115,595,880</b>	<b>1,256,958,550</b>
2023 оны 1-р сарын 1 үлдэгдэл	92,323,003	49,039,667	1,115,595,880	1,256,958,550
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>92,323,003</b>	<b>49,039,667</b>	<b>1,115,595,880</b>	<b>1,256,958,550</b>
Тайлант үеийн үр дүн	-	-	28,302,859	28,302,859
2023 оны 12-р сарын 31 үлдэгдэл	<b>92,323,003</b>	<b>49,039,667</b>	<b>1,143,898,738</b>	<b>1,285,261,408</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
2	<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	431,069,600.00	377,868,277.45	53,201,322.55
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	431,069,600.00	377,868,277.45	53,201,322.55
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	431,069,600.00	377,868,277.45	53,201,322.55
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	300,363,100.00	261,977,872.17	38,385,227.83
210101	Үндсэн цалин	198,632,100.00	192,438,250.92	6,193,849.08
210102	Нэмэгдэл	93,510,400.00	52,500,407.25	41,009,992.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	9,760,000.00	(9,760,000.00)
210104	Урамшуулал	8,220,600.00	7,279,214.00	941,386.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,545,000.00	32,908,789.69	4,636,210.31
210201	Тэтгэврийн даатгал	25,530,700.00	22,386,825.72	3,143,874.28
210202	Тэтгэмжийн даатгал	3,003,600.00	2,619,446.02	384,153.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,402,800.00	2,121,322.59	281,477.41
210204	Ажилгүйдлийн даатгал	600,600.00	524,716.89	75,883.11
210205	Эрүүл мэндийн даатгал	6,007,300.00	5,256,478.47	750,821.53
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,481,900.00	41,469,735.59	12,164.41
210301	Гэрэл, цахилгаан	5,551,300.00	5,551,235.59	64.41
210302	Түлш, халаалт	34,996,000.00	34,996,000.00	-
210303	Цэвэр, бохир ус	934,600.00	922,500.00	12,100.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>36,053,100.00</b>	<b>26,024,580.00</b>	<b>10,028,520.00</b>
210502	Хоол, хүнс	36,053,100.00	26,024,580.00	10,028,520.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,134,100.00</b>	<b>3,134,100.00</b>	-
210604	Урсгал засвар	3,134,100.00	3,134,100.00	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>666,600.00</b>	<b>666,300.00</b>	<b>300.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	666,600.00	666,300.00	300.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,825,800.00</b>	<b>11,686,900.00</b>	<b>138,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,825,900.00	9,688,400.00	137,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,999,900.00	1,998,500.00	1,400.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>386,453,600.00</b>	<b>333,264,441.86</b>	<b>53,189,158.14</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	386,453,600.00	333,264,441.86	53,189,158.14

<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>44,616,000.00</b>	<b>44,603,835.59</b>	<b>12,164.41</b>
122005	Орон нутгийн төсвөөс	44,616,000.00	44,603,835.59	12,164.41
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	1,104,145.00	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	54,293,303.14	

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Жилийн эцсийн аудитаар нийт 7,966.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 7,818.5 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай 1 зөвлөмж, 148.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож хүргүүллээ.

Дээрх төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан томилолттой 3 албан хаагчид хоолны мөнгийг давхардуулан олгосон, мөн 1 албан хаагчид томилолтын мөнгийг илүү тооцож олгосон	1	148.0	1	148.0		-						
Төлбөрийн И-баримтаар баталгаажуулаагүй ажил гүйлгээг бүртгэсэн.	1	7,818.5					1	7,818.5				
Дүн	<b>3</b>	<b>7,966.5</b>	<b>1</b>	<b>148.0</b>			<b>1</b>	<b>7,818.5</b>				